



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/02/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал

Утас: 99432788 Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ШИНЭ ХОВД ББХК  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Ш.БАТЖАРГАЛ ТАНАА

2024.03.22 № 1/180  
танай 2024.02.20-ны № 04/14 -т

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай жууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг ТУЗ-аар батлуулаагүй, Хувийн хэвшлийн компанийг эрх шилжүүлэх болон худалдан авах гэрээ байгуулан өөрийн эзэмшилдээ шилжүүлэн авсан, санхүүгийн тайланд орлогыг зөрүүтэй тайлагнасан, бусад байгууллагад хандив өгсөн, бие даасан хуулийн этгээдэд санхүүжилт олгосон, хөрөнгө борлуулсны орлогыг холбогдох байгууллагад дутуу төвлөрүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, бараа материалыг орлогод авч тооцоог бодоогүй зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4-д "Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих", 20 дугаар зүйлийн 3-д "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 16 дугаар зүйлийн 3-д "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 25 дугаар зүйлийн 25.10-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Нягтлан

бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.5-д "бүх орлого" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Оршин байх", "Эрх ба үүрэг" "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орон нутгийг дэмжих Шинэ хөдөө төслийн хүрээнд 6,370,387.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн.

#### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт авч үзсэн болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

"ШИНЭ ХОВД - 2030" хөгжлийн шинэ шатанд хүргэх төслийн хүрээнд үйлдвэрлэлийн 29 төсөл, хөдөө аж ахуйн чиглэлээр 13 төсөл, дэд бүтцийн 9 төсөл, үйлчилгээ, аялал жуулчлалын чиглэлээр 8 төсөл, нийгэм, хотын хөгжлийн чиглэлээр 8 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

**Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан. (төгрөгөөр)**

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1.ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1.Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	39,139,829.30	10,526,355.40
1.1.2. Дансны авлага	23,663,400.00	120,314,000.00
1.1.3. Татвар НДШ-ийн авлага		
1.1.4. Бусад авлага	2,004,724.81	2,304,724.81
1.1.5.Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6.Бараа материал	36,896,238.60	36,896,238.60
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		
1.1.8. Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
1.1.10		
<b>1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>101,704,192.71</b>	<b>170,041,318.81</b>
<b>1.2. Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1 Үндсэн хөрөнгө	1,163,956,386.39	4,529,494,597.42
1.2.2 Биет бус хөрөнгө	937,500.00	18,842,334,000.00
1.2.3 Биологийн хөрөнгө		
1.2.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6 Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8 Бусад эргэлтийн бус хөрөнгө		
<b>1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,164,893,886.39</b>	<b>23,371,828,597.42</b>
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,266,598,079.10</b>	<b>23,541,869,916.23</b>
<b>2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1 Өр төлбөр</b>		
<b>2.1.1 Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1 Дансны өглөг	316,890,481.60	1,248,885,481.60
2.1.1.2 Цалингийн өглөг		
2.1.1.3 Татварын өр		7,405,507.78
2.1.1.4 НДШ-ийн өр		
2.1.1.5 Банкны богино хугацаат зээл		
2.1.1.6 Хүүний өглөг		
2.1.1.7 Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8 Урьдчилж орсон орлого		
2.1.1.9 Нөөц өр төлбөр		
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	10,142,648.51	16,648,592.00
2.1.1.11 Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөд хам		
<b>2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>327,033,130.11</b>	<b>1,272,939,581.38</b>
2.1.2 Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1 Урт хугацаат зээл		
2.1.2.2 Нөөц өр төлбөр		
2.1.2.3 Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5 Зээл		
<b>2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>0.00</b>
<b>2.2 Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>1,272,939,581.38</b>
2.3 Эздийн өмч		
2.3.1 Төрийн	2,000,000.00	2,000,000.00
2.3.2 Хувийн		

2.3.3 Хувьцаат		
2.3.4 Халаасны хувьцаа		
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	967,819,330.00	22,267,485,330.00
2.3.9 Хуримтлагдсан ашиг	-30,254,381.01	-554,995.15
2.3.10		
2.3.11 Эздийн өмчийн дүн	<b>939,564,948.99</b>	<b>22,268,930,334.85</b>
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,266,598,079.10</b>	<b>23,541,869,916.23</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан. (ТӨГРӨГӨӨР)

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
<b>1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)</b>	<b>195,568,200.00</b>	<b>294,000,000.00</b>
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	188,514,600.00	266,588,348.70
<b>3. Нийт ашиг (алдагдал)</b>	<b>7,053,600.00</b>	27,411,651.30
4. Түрээсийн орлого		25,985,408.00
5. Хүүний орлого		216,908.03
6. Ногдол ашгийн орлого		
7. Эрхийн шимтгэлийн орлого		
8. Бусад орлого	24,336,000.00	367,358,269.23
9. Борлуулалт, маркетингийн зардал		
10. Ерөнхий ба удирдлагын зардал	22,229,300.00	378,972,918.90
11. Санхүүгийн зардал		
12. Бусад зардал	41,698,200.00	9,000,000.00
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17. Бусад ашиг (алдагдал)		
<b>18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-32,537,900.00</b>	<b>32,999,317.66</b>
19. Орлогын татварын зардал		3,299,931.80
<b>20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-32,537,900.00</b>	<b>29,699,385.86</b>
<b>21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)</b>		
<b>22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-32,537,900.00</b>	<b>29,699,385.86</b>
<b>23. Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
<b>24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>-32,537,900.00</b>	<b>29,699,385.86</b>
<b>25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан. (ТӨГРӨГӨӨР)**

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	<b>2,000,000</b>	<b>967,819,330</b>	<b>(30,254,381)</b>	<b>939,564,949</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл	2,000,000	967,819,330	(30,254,381)	<b>939,564,949</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн				-
1	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	<b>2,000,000</b>	<b>967,819,330</b>	<b>(30,254,381)</b>	<b>939,564,949</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл				-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			29,699,386	<b>29,699,386</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт		21,299,666,000		<b>21,299,666,000</b>
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	<b>2,000,000</b>	<b>22,267,485,330</b>	<b>(554,995.15)</b>	<b>22,268,930,334.85</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан. (ТӨГРӨГӨӨР)**

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>329,962,238.73</b>	<b>785,370,175.74</b>
<b>1.1 Мөнгөн орлогын дүн</b>	<b>329,962,238.73</b>	<b>785,370,175.74</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	329,962,238.73	420,635,495.00
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		364,517,772.71
Бусад мөнгөн орлого		216,908.03
<b>1.2 Мөнгөн зарлагын дүн</b>	<b>347,443,861.79</b>	<b>798,038,649.64</b>
Ажиллагчдад төлсөн	75,892,611.28	136,428,914.35
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,726,781.00	16,934,912.00
Бараа материал худалдан авахад төлсөн	30,650,652.00	92,688,392.00
Ашиглалтын зардал төлсөн		71,342,167.73
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн		6,131,285.91
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	232,173,817.51	474,512,977.65
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(17,481,623.06)</b>	<b>(12,668,473.90)</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	<b>15,945,000.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		15,945,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	<b>(15,945,000.00)</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>		-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(17,481,623.06)	(28,613,473.90)
<b>Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>56,621,452.36</b>	<b>39,139,829.30</b>
<b>Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>39,139,829.30</b>	<b>10,526,355.40</b>

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,416,045.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11,877,100.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг<sup>1</sup> залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үйл ажиллагааны орлогоо зөрүүтэй тайлагнасан 340,825.6 мянган төгрөгийн орлого бүртгүүлэн,
- Тушаал шийдвэргүйгээр дуусаагүй төслийн үйл ажиллагааны зардлыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн 7,080,000.0 мянган төгрөгийн, Шинэ хөдөө ховд 4 багц тоног төхөөрөмжийн нийлүүлэх ажлын 1-р багцын 4,456,275.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн аваагүй байж хөрөнгөөр бүртгэснийг хасуулан залрууллаа.

Залруулагдаагүй нийт 538,945.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 538,945.1 мянган төгрөгийн 8 зөрчил<sup>2</sup> илэрснээс 384,000.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага бичиж, 86,100.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 68,845.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн 3 акт тогтоож хүргүүллээ. Үүнд:

#### 3.1.1 Авлагатай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Ховд агра парк ХХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор олгосон 74,600.0 мянган төгрөгийг зардалд тусгасан нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоох

#### 3.1.2 Өглөгтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** 2022 онд Вива зоне ХХК-тай байгуулсан техник тоног төхөөрөмжийг зээлээр худалдах, худалдан авах гэрээний эргэн төлөлтөөс орж ирсэн 10,000.0 мянган төгрөгийг Хөдөө аж ахуйн корпораци ХХК-д шилжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоох

#### 3.1.3 Зардалтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Худалдааны байгууллагын холбооны 100 жилийн ойд 1000.0 мянган төгрөгийн, Мал эмнэлгийн шинэ жилд 500.0 мянган төгрөгийн хандив өгсөн нийт 1500.0 мянган төгрөгийг зарцуулсан нь ТБОНӨ тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3-д “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 25.10-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоох

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 АЛБАН ШААРДЛАГА

#### 5.2.1 Бүтэц зохион байгуулалт, төлөвлөлттэй холбоотой

Илрүүлэлт: Иргэн Д.Нямдаваагийн өмчлөлийн Ховд агро парк ХХК-ийг Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-т 2023 оны 01 дүгээр сарын 12 -ны өдөр компанийн эрх шилжүүлэх гэрээ болон худалдах, худалдан авах гэрээ байгуулан шилжүүлэн авсан. Шилжүүлэн авсан компанийн хөрөнгийн үнэлгээ хийгээгүй бөгөөд балансын дүнгээр 332,147.4 мянган төгрөгийн хөрөнгө, 384,667.0 мянган төгрөгийн өртэй байсан. Мөн Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ нь 2023 оны төсөв, төлөвлөгөөгөө гаргаж ТУЗ-аар батлуулаагүй байна. Эдгээр зөрчлүүд ТБОНӨ-ийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4-д “Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”, 20 дугаар зүйлийн 3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, аймгийн ИТХ-ын 2023 оны 13/02 дугаар тогтоолын 3-д “Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны явц үр дүнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд даалгасугай” гэсэн заалтуудтай нийцэхгүй, ИТХ-ийн тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 179 дугаар тогтоолыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Албан шаардлага өгөх

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.3.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худаг угсралтын нэмэлт материал үнэ 8000.0 мянган төгрөгийг Топдринлинг компанид шилжүүлсэн материалыг орлогод аваагүй, Цөгц нуур ХХК-д 20,000.0 мянган төгрөг шилжүүлсэн дэмжих баримтгүй, Талст чиглэл ХХК-тай 10,000.0 мянган төгрөг гэрээгүй, Энх мөнх дүүрэн тамир ХХК-д 4000.0 гэрээгүй, ажилчдын томилолтын зардал 11,276.0 мянган төгрөг илтгэх хуудас тайлан, томилолтын хуудас дутуу болон Онцгой байдлын газар, Зэвсэгт хүчний 123-р анги, Ховд Хорих 457-р анги гэсэн байгууллагад мөсний баярын зардал шилжүүлсэн нь анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж байж ажил гүйлгээг хийж байх.

#### 3.3.2. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авсан шатахууныг бараа материалын орлогод аваагүй, зарцуулалтыг хянахад жолоочийн тооцооны хуудасгүй, шатахууны тооцоо бодоогүй, шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар 5 дахь хэсгийн 4-т “Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана” гэсэн заалттай нийцэхгүй, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм” тогтоосон журмыг баримтлаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууныг бараа материалын тайланд орлогод авч, тооцоог бодож зарлагад гаргаж хэвших.

**3.3.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:**

**Илрүүлэлт:** Тус байгууллага 2023 онд Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд оруулбал зохих мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан, 124 мэдээллийг оруулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-д “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан мэдээлнэ” гэсэн заалттай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨҮГ	Үйл ажиллагааны орлогоо зөрүүтэй тайлагнасан	1	340,825.6	1	340,825.6			1	340,825.6				
	Тушаал шийдвэргүйгээр дуусаагүй төслийн үйл ажиллагааны зардлыг болон хүлээн аваагүй зүйлсийг хөрөнгөд бүртгэсэн	1	11,536,275.0			1	11,536,275.0	1	11,536,275.0				
<b>Нийт дүн</b>		<b>2</b>	<b>11,877,100.6</b>	<b>1</b>	<b>340,825.6</b>	<b>1</b>	<b>11,536,275.0</b>	<b>2</b>	<b>11,877,100.6</b>				

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨҮГ	Цэвэр хөрөнгөгүй, өртэй хувийн хэвшлийн компанийг өөрийн эзэмшилдээ шилжүүлэн авсан, ТУЗ-аас баталсан, төсөв төлөвлөгөөгүй	1	384,000.0			1	384,000.0				
	Ховд агра парк ХХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор санхүүжилт олгосон	1	74,600.0	1	74,600.0						
	Төрийн болон төрийн бус байгууллагад хандив өгсөн	1	1,500.0	1	1,500.0						
	техник тоног төхөөрөмжийг зээлээр худалдах, худалдан авах гэрээний эргэн төлөлтөөс орж ирсэн мөнгийг зээлдүүлэгчид шилжүүлээгүй	1	10,000.0	1	10,000.0						

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	65,585.02					1	65,585.0		
	Бараа материалыг орлогод авч бүртгээгүй, жишиг нормоор тооцоо бодоогүй	1	3,260.12					1	3,260.12		
	<b>ДҮН</b>	<b>6</b>	<b>538,945.1</b>	<b>3</b>	<b>86,100.0</b>	<b>1</b>	<b>384,000.0</b>	<b>2</b>	<b>68,845.1</b>		

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	
Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨҮГ	Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроосон болон мэдээлээгүй.	1							1	
<b>Нийт дүн</b>		<b>1</b>							<b>1</b>	

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

5.1 аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			